



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 5/03

Чингис хот

**Б.Хуланг албан үүргийг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 28 дугаар зүйлийн 28.3, 57 дугаар зүйлийн 57.1, 57.2, 57.2.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 274 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” 277 дугаар тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүү, төрийн сангийн хэлтсийн Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй Банзарсүрэнгийн Хуланг 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн томилсугай

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

С.Нямдаваа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Цэцэгсүрэн

Төсвийн орлого, хөрөнгө оруулалтын

санхүүжилт хариуцсан мэргэжилтэн

Т.Бямбадулам

Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа

Нярав

3. Б.Хулангийн цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоон үндсэн цалин 594803 /таван зуун ерэн дөрвөн мянга найман зуун гурав/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Г.Ариунхүү/-д зөвшөөрсүгэй.

4. Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Хуланд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР